

**НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ
КОМПАНИЙН ТАЙЛАН**



2025



АГУУЛГА

1. Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

2.1 Туйлын зорилго, Хэтийн зорилго, Үнэт зүйлс

2.2 2025 оны зорилго, бүтэц, бүрэлдэхүүн

2.3 Онцлох контент

2.4 Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа

2.5 Дижитал хөгжүүлэлт

2.6 Хөдөлмөрийн нөөц

2.7 Нийгэмд тустай ажлууд

3. Компанийн засаглал

3.1 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ

3.2 Хувьцаа эзэмшигчидийн хурлын тайлан

3.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тайлан

3.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлан

3.5 Дотоод хяналт

3.6 Шийдвэрүүд хууль, журамтай нийцэж байгаа байдал

4. Санхүүгийн үйл ажиллагааны тайлан

5. Хараат бус аудитын тайлан, дүгнэлт

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагч, түншүүд болон хамт олон та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

"Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн хувьд 2025 он бол сорилт болон шинэ боломжуудыг нээсэн, ирээдүйн өсөлтийн бат бэх суурийг тавьсан онцлог жил болж өнгөрлөө.

Хэдийгээр өнгөрсөн онд бид багагүй сорилтуудтай нүүр тулсан хэдий ч, тулгарсан саад бэрхшээлийг үр дүнтэй даван туулж, цаашдын стратегиа илүү оновчтой болгож чадсан юм. Энэхүү хүчин чармайлтын үр дүнд бид дараах томоохон эерэг өөрчлөлтүүдийг бий болгож, амжилттай ажиллалаа:

- Зээлдэгчийн амь насны даатгал, тэр дундаа ипотекийн зээлийн даатгалын чиглэлээр бид бизнесийн шинэ орон зайг амжилттай нээж, банкнуудтай хамтын ажиллагаагаа стратегийн түвшинд өргөжүүллээ.
- Салбарын зохицуулалтын таатай орчин бүрдэж, бидний үндсэн үйл ажиллагааны давуу талтай нийцэж байгаа нь энэхүү чиглэлд хурдацтай тэлэх томоохон хөшүүрэг болж байна. Одоогоор бидний хүрээд буй үр дүн бол цаашдын асар их боломж, урт хугацааны өсөлтийн зөвхөн эхлэл бөгөөд бид нийгэмд ач холбогдолтой энэхүү чухал үйл ажиллагаанд хамгийн өндөр мэдлэг түршлагатай, мэргэжлийн оролцогч байсаар байх болно.
- Харилцагчид даатгалын хураамжаа саадгүй төлөх, нөхөн төлбөрөө мэдээлэх, хянах боломж бүхий "Mylife" интерактив портал болон даатгалын зуучлагч, төлөөлөгчдөд шууд баталгаа гаргах боломжийг олгох "ibroker" платформыг тус тус амжилттай хөгжүүлж, цахим шилжилт болон үйлчилгээний хүртээмжид томоохон үсрэлт гаргалаа.
- Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд нөхөн төлбөрийн мониторингийн шийдлийг амжилттай нэвтрүүлсэн бөгөөд энэ нь бидний өдөр тутмын үйл ажиллагааг чанартай, эмх цэгцтэй болгосноор нөхөн төлбөрийн харьцааг тогтвортой удирдан хянах бодит боломжийг бүрдүүлж чадсан чухал ахиц байлаа.

Эдгээр хэрэгжүүлсэн томоохон төслүүд болон эерэг үр дүнгүүд нь биднийг 2026 онд орлогоо тогтвортой өсгөх, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх маш таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Ирэх 2026 онд бид үйл ажиллагааныхаа уялдаа холбоог сайжруулах, дотоод системийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, мөн хуримтлалын даатгалын үйлчилгээний цар хүрээг тэлэх зэрэгт онцгойлон анхаарч ажиллах болно. Түүнчлэн, бидний хамгийн үнэ цэнтэй хөрөнгө болсон ажилтнуудынхаа мэдлэг, үр чадварыг тасралтгүй нэмэгдүүлэх, карьер хөгжлийг дэмжихэд түлхүү анхаарч, шилдэг баг хамт олныг төлөвшүүлэх нь бидний тэргүүний зорилтуудын нэг байх болно.

Биднийг үргэлж дэмжин, хамтран ажилладаг харилцагч, түншүүд болон компанийнхаа нийт хамт олонд гүн талархал илэрхийлье. Бид хамтдаа улам илүү ихийг бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,
Г.Монголхүү Гүйцэтгэх захирал
"Нэйшнл лайф даатгал" ХХК



1 КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН






2.1 ТУЙЛЫН ЗОРИЛГО, ХЭТИЙН ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС



ҮНЭТ ЗҮЙЛС



ХЭТИЙН ЗОРИЛГЫН АРГА ЗАМ, ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ЗУРАГЛАЛ






2.2 ЗОРИЛГО, БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

"Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн 2025 оны зорилго: Хөдөлмөр, зардлын бүтээмж болон хураамжийн орлогын өсөлтийг нэмэгдүүлэх, таниулах үйл ажиллагааны үр дүнг сайжруулах замаар компанийн үр шимийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 22-ны 02/25-29 тоот тогтоолоор газар нэгж бүтцийн зохион байгуулалтад өөрчлөлт оруулан батлав.


Бүтцийг зургаар үзүүлбэл:





2.3 ОНЦЛОХ КОНТЕНТ

1. Дэлхийн Монголчуудын радио MGL радиотой бүтэн жилийн гэрээ байгуулан радио сонсогч иргэддээ амьдралын даатгалын ач холбогдлыг таниулах, мэдлэг олгох контентуудыг бүтээн олон нийтэд хүргэсэн.



2. “Анухай фитнес шоу” нэвтрүүлгийн 11 дугаарын турш алтан ивээн тэтгэгчээр хамтран ажиллаж, оролцогчдыг “Энхжин” хувийн эрүүл мэндийн даатгалд хамруулан, урьдчилан сэргийлэх үзлэг, эмнэлгийн тусламж үйлчилгээний хамгаалалтыг хариуцан ажиллав.

3. Компанийн төв салбар хотын төвийн шинэ байршил руу нүүж, харилцагчдад илүү ойр, хүртээмжтэй орчинд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүллээ. Ингэснээр харилцагчдад илүү ойр, илүү нээлттэй, илүү таатай орчинд үйлчлэх боломжийг бүрдүүлэв.





2.3 ОНЦЛОХ КОНТЕНТ

4. ХНН “УБТЗ”-ЫН АЖИЛТАНД ЗОРИУЛСАН “ХУРИМТЛАЛТАЙ ТӨМӨР ЗАМЧИН” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖ ҮҮЛЭВ.

ХНН “УБТЗ”-ын хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор ажилтнууддаа зориулсан хувийн нэмэлт тэтгэврийн сан үүсгэн байгуулах ажлын хүрээнд ажилтны санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын үр өгөөж, сайн дурын үндсэн дээр амьдралын урт хугацааны даатгал-хуримтлалд хамрагдахын ач холбогдлын таниулах “Өрхийн санхүүгийн эрсдэлээ удирдах нь” цуврал сургалтыг хамтран зохион байгууллаа.




5. ХҮНИЙ НӨӨЦ УДИРДАХ АЖИЛТАНД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭВ.

Байгууллагын хөгжлийн хөдөлгүүр болсон удирдах ажилтнууд болон хүний нөөцийн мэргэжилтнүүдэд зориулсан “Мэдлэг түгээе” эвентийг байгууллагын хүний нөөцийн

хөгжлийн цогц хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэгч Эн Пи Си Энд Мандал ХХК-тай хамтран зохион байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд удирдлагын арга барилыг сайжруулах, ажилтнуудыг хөгжүүлэх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, ажилтнаа урт хугацаанд тогтоон барих оновчтой шийдлүүдийг санал болгон хамтран ажиллаа.

6. ДААТГАЛЫН ШИНЭЧЛЭЛ БА ИРГЭДИЙН ХАМГААЛАЛ

Ипотекийн зээлдэгчдэд чиглэсэн хууль эрх зүйн шинэ зохицуулалтын хүрээнд “Урт хугацааны амь насны даатгал”-ын ач холбогдлыг олон нийтэд таниулах, иргэдийн даатгалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэн таниулах үйл ажиллагааг өрнүүлэв.





2.4 ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

ХЭРЭГЛЭГЧ ТӨВТЭЙ ЧАНАРЫН УДИРДЛАГА (ISO 9001:2015)

Манай байгууллага үйл ажиллагаандаа ISO 9001:2015 олон улсын стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна. Энэхүү стандартын хүрээнд үйлчлүүлэгчийг ямагт "Нэгдүгээрт" тавьж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжууллаа.

Үр дүнд: Судалгааны үр дүнд үндэслэн үйлчилгээний алдаа доголдлыг арилгах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанарыг тасралтгүй сайжруулан ажиллаж байна.





2.5 ДИЖИТАЛ ХӨГЖҮҮЛЭЛТ

1. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

- ОУЭМД-ыг зах зээлийн жишиг хэв шинжүүд, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, нөхөн төлбөрийн өгөгдөлд үндэслэн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн шинэчлэлт хийв.
- Эрүүл мэндийн даатгалы бүтээгдэхүүний хүрээнд БНХАУ-ын Ping An даатгалын компанитай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.



ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ



ОРОН СУУЦНЫ ХУРИМТЛАЛЫН ДААТГАЛ





ИПОТЕКИЙН ЗЭЭЛДЭГЧИЙН АМЬ НАСНЫ ДААТГАЛ

- Орон сууцны хуримтлалын даатгалын бүтээгдэхүүнийг 2025 онд төгөлдөржүүлснээр Хөгжлийн банктай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.

- Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг тусган шинэчлэн батлуулав.

2. Дижитал шийдэл

Харилцагчид даатгалын хураамжаа саадгүй төлөх, нөхөн төлбөрөө мэдээлэх, хянах боломж бүхий "Mylife" интерактив портал болон даатгалын зуучлагч, төлөөлөгчдөд шууд баталгаа гаргах боломжийг олгох "ibroker" платформыг тус тус амжилттай хөгжүүлж ажиллав.





2.6 ХӨДӨЛМӨРИЙН НӨӨЦ

Ажилтны сургалт хөгжил

2025 онд шинээр ажилд орсон ажилтнуудыг “Цэгтэй сэтгэх арга”, “Ажил гүйцэтгэх алгоритм” зэрэг системийн мэдлэг олгох сургалтад хамруулж, шаардлагатай суурь ойлголтыг бүрдүүлсэн.

Мөн ажилтнуудын тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор улирал бүр “Ажилтны үр чадварын оношилгоо”-г зохион байгуулж, хувь хүний сонирхол, хүсэл тэмүүлэлд нийцсэн хөгжлийн боломжийг бүрдүүлсэн.

Тус оношилгооны үр дүнд ажилтнууд өөрсдийн үр чадварын дутагдлыг тодорхойлж, 2025 онд нийт 122 үр чадвараа хөгжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.



Ажилтны сургалт хөгжил

Ажилтнуудын хоорондын харилцааг бэхжүүлэх, багийн уур амьсгалыг сайжруулах, хувь хүний өөрийгөө илэрхийлэх болон хамт олондоо хүлээн зөвшөөрөгдөх хэрэгцээг дэмжих зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг спорт, идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүдийг тайлант хугацаанд амжилттай хэрэгжүүлэв.

Тухайлбал, ширээний теннис, дартс, биллиард болон цахим спортын төрлүүдээр олон төрлийн тэмцээн зохион байгуулж, нийт ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Эдгээр арга хэмжээнүүд нь ажилтнуудын бие бялдрын идэвхийг дэмжихээс гадна харилцан ойлголцол, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжид эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой байв.

Мөн тэмцээнүүдийг тогтмол, хүртээмжтэй байдлаар зохион байгуулснаар байгууллагын соёл, дотоод уур амьсгалыг бэхжүүлж, ажилтнуудын сэтгэл ханамж, байгууллагад хандах хандлагыг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулсан болно.



2.6 ХӨДӨЛМӨРИЙН НӨӨЦ

Ахмад ажилтнууддаа хүндэтгэл үзүүлэв.

Компани үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн байгууллагын хөгжил, үнэ цэнийг бүтээлцэж ирсэн ахмад ажилтнууддаа Ахмадын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж, тайлант хугацаанд амжилттай хэрэгжүүлэв.

Тус арга хэмжээний хүрээнд ахмад ажилтнуудын олон жилийн хөдөлмөр, туршлага, байгууллагад оруулсан хувь нэмрийг онцлон талархал илэрхийлж, хүндэтгэл үзүүлэн дурсгалын гарын бэлэг гардуулав. Мөн үе үеийн ажилтнуудын уялдаа холбоог бэхжүүлэх, туршлага солилцох, байгууллагын үнэт зүйлсийг залгамжлуулах зорилгоор уулзалт, дурсамж хуваалцах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээ нь ахмад ажилтнуудын байгууллагатайгаа холбоотой байх сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхээс гадна залуу ажилтнуудад байгууллагын түүх, соёл, үнэт зүйлсийг таниулах, хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой байв. Мөн байгууллагын дотоод уур амьсгалыг эерэгээр дэмжиж, үе хоорондын залгамж холбоог бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан болно.





НИЙГЭМД ТУСТАЙ АЖЛУУД

1. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Нийслэлийн Сүхбаатар дүүргийн өрхийн эмнэлгүүдэд иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, Genrui FA50 иммунологийн анализатор төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэн ажиллав.



2. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд харилцагч компанийн нуруу нугасны хүнд хэлбэрийн эмгэгийн үлмаас яаралтай гадаад улсад өндөр өртөгтэй мэс засал хийлгэх шаардлагатай болсон ажилтанд зориулсан хандивын аянд оролцож, дэмжлэг үзүүлэв.

3. Нэмэлт тэтгэвэртэй болох боломжийг бүрдүүлж тэтгэврийн даатгалыг санал болгосноор 2025 онд шинээр 237 хүнд даатгуулагчд 1.1 тэрбум төгрөгийн нэмэлт тэтгэврийг олгож ажиллаа. Энэхүү үйл ажиллагаа нь иргэдийн ирээдүйн санхүүгийн баталгааг дэмжих, нийгэмд эерэг нөлөө үзүүлж буй юм.



2 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ





КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

3.1 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсан бөгөөд Компани нь зохицуулалттай этгээд болохын хувьд жил бүр өөрийн үнэлгээг хийж Санхүүгийн зохицуулах хороогоор хянан баталгаажуулж ажиллаж байна.

2025 онд Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг 2024 онтой харьцуулахад 11.11%-аар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд Төлөөлөн удирдах зөвлөл (ТҮЗ)-ийн үйл ажиллагааны тайланг тогтмол, стандартын дагуу боловсруулж, холбогдох этгээдүүдэд хугацаанд нь тайлагнаж хэвшсэн нь голлон нөлөөллөө. Үүний үр дүнд компанийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоо сайжирч, компанийн засаглалын хэрэгжилтийн чанар бодитоор ахисан байна.

Кодексийн шаардлага /бүлгээр/	Авбал зохих оноо	2022 оны үнэлгээ	2023 оны үнэлгээ	2024 оны үнэлгээ	2025 оны үнэлгээ
1 НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	12	5	10	8	10
2 ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ	10	4	7	6	7
3 ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	6	3	4	4	6
4 ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО	6	5	6	6	6
5 ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	8	4	8	8	8
6 ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ	6	5	6	6	6
7 ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ	8	7	8	7	8
8 НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ	6	5	4	5	5
9 ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ	10	9	10	8	10
Нийт	72	47	63	58	66
Үнэлгээний хувь	100%	65.20%	87.50%	80.56%	91.67%




КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

3.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тайлан

Нэйшнл лайф даатгал ХХК-ийн энгийн хувьцааг Эф Эс Си Өү ХХК нь 99.96 хувийг, компанийг үүсгэн байгуулснаас хойших хугацаанд үнэ цэн бүтээлцсэн 35 иргэн 0.04 эзэмшдэг.

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг баталгаажуулах, Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг шинэчлэн батлах, Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах гэсэн 3 асуудлыг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Хувьцаа эзэмшигчийн бүтэц





КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

3.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тайлан


Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Компанийн дүрэм, ТУЗ-ийн хурлын журамд заасан чиг үүргийн хүрээнд 2025 онд улирал бүрийн ээлжит хурлаар 32 асуудлыг, 5 удаагийн ээлжит бус хурлаар 33 асуудлыг хэлэлцэж, нийт 9 удаа 65 цаг хуралдав.

Хурлын хэлбэр	Хуралдсан огноо	Хурлын ирц	Нийт цаг
1 Ээлжит	2025/01/16 2025/02/04	2025 оны 01 дүгээр сарын 16, 02 дугаар сарын 04-ний өдрийн хурлын ирц 100%	7.5
2 Ээлжит бус	2025/03/29	2025 оны 03 дугаар сарын 29-ний хурлын ирц 100%	2
3 Ээлжит бус	2025/04/10 2025/04/15 2025/04/23	2025 оны 04 дүгээр сарын 10, 04 дүгээр сарын 15, 04 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын ирц 100%	8.5
4 Ээлжит бус	2025/06/04	2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлын ирц 100%	5.5
5 Ээлжит	2025/07/28 2025/08/06	2025 оны 07 дугаар сарын 28, 08 дугаар сарын 06 -ны өдрийн хурлын ирц 100%	11.5
6 Ээлжит бус	2025/10/17 2025/10/28	2025 оны 10 дугаар сарын 17, 10 дугаар сарын 28-ний өдрийн хурлын ирц 100%	9.5
7 Ээлжит бус	2025/11/27 2025/12/3 2025/12/9	2025 оны 11 дүгээр сарын 27, 12 дугаар сарын 03, 12 дугаар сарын 09-ний өдрийн хурлын ирц 100%	11.5
8 Ээлжит бус	2025/12/16	2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлын ирц 100%	6
9 Ээлжит бус	2025/12/16	2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлын ирц 80%	3
Нийт			65




КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

2025 онд хэлэлцсэн асуудлын ангилал



Хурлаар асуудлыг шийдвэрлэж буй байдал

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2020 оноос хойших хугацаанд дунджаар 40 орчим асуудлыг хэлэлцдэгээс 70 орчим хувийг баталж, 16.5 орчим хувийг шийдвэр гаргахад шаардлагатай баримт бичиг, судалгааг хангалтгүй хийсэн шалтгаанаар буцааж шийдвэрлэсэн.





КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

3.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлан

Компани нь 2025 онд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд хамаарах 5 хуулийн этгээд, 1 эрх бүхий албан тушаалтантай гэрээ байгуулахад Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу саналын эрхтэй ТҮЗ-ийн гишүүдийн саналаар гэрээгээр гүйцэтгэх ажил гүйлгээ зах зээлийн үнээр хийгдэх эсэх, тухайн ажил үйлчилгээнээс бий болох материаллаг болон материаллаг бус үнэ цэнийг харгалзан 607.5 сая төгрөгийн үнийн хязгаар бүхийхэлцэл хийх зөвшөөрлийг ТҮЗ-өөс олгож шийдвэрлэв.

Сонирхлын зөрчилтэй этгээдийн нэр	Сонирхлын зөрчилтэй хэлцлийн нэр	Хэлцлийн үргэжлэх хугацаа	Хэлцлийн үнийн дүн /төгрөгөөр/	Бодит гүйцэтгэл 2025/12/15 /төгрөгөөр/	
1	Оффис ашиглалтын гэрээ	1 жил	7.6 сая	6.6 сая	
2	Гүнд Инвестмент ХХК	Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээний нэмэлт, өөрчлөлт	8 сар	48 сая	
3		Ажил гүйцэтгэх гэрээ	1 жил	58 сая	
4		Оффис түрээсийн гэрээ	1 жил	57.2 сая	10.5 сая
5	Рийч пойнт ХХК	Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ	1 жил	5.2 сая	4.2 сая
6		Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ /2026 сунгалт/	1 жил	6.1 сая	-
7		Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ	4 сар	2.1 сая	-
8	Синержи ФандСолюшн ҮЦК ХХК	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ	1 жил	73.3 сая	57,619,248
9		Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ /2026 сунгалт/	1 жил	48.8 сая	-
10	ТҮС Солюшн ХХК	Серверийн үйлчилгээ үзүүлэх гэрээ	1 жил	18 сая	9.5 сая
11	Эф Эс Си Өү ХХК	Менежментийн үйлчилгээний гэрээ 2025	5 сар	62.5 сая	38,900,000
12		Менежментийн үйлчилгээний гэрээ /2026 сунгалт/	1 жил	165 сая	-
13		Програм ашиглалтын гэрээ-1	1 жил	49.5 сая	49,500,000
14		Програм ашиглалтын гэрээ-2	1 жил	6 сая	3,000,000
Нийт			607.4 сая	287.9 сая	



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


3.5 Дотоод хяналт

Компанийн дотоод хяналтыг Оношилгоо, мониторингийн журам, Мэдээллийн урсгалын журам, Санхүүгийн үйл ажиллагааны журмын дагуу компанийн дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Системийн мониторинг

"Нэйшнл Лайф Даатгал" ХХК нь 2015 оноос үйл ажиллагаандаа системийн ОНОЛД суурилсан "байгууллага зорилгоо тогтвортой хэрэгжүүлэх чадвартай тогтолцоог бий болгодог" менежментийн ТУС загварыг нэвтрүүлж байгаа билээ. Энэхүү загвар нь компанийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүргийг уялдуулсан шийдлүүдээ гарган, хэрэгжилтэд нь мониторинг, оношилгоо хийж, тэдгээрт үндэслэн сайжруулалтыг тогтмол төлөвлөж хэрэгжүүлэх замаар дотоод хяналт тасралтгүй хэрэгжүүлдэг загвар юм.

Энэхүү загварыг хэрэгжүүлэх эхний үе шатанд 5 суурь тогтолцоог бүрдүүлдэг шийдлүүдээ гарган үйл ажиллагааны 5 функцийн хүрээнд хэрэгжүүлдэг ба үүнийг зурагт үзүүлбэл:



P – Plan – Төлөвлөх, D – Do – Хийх, C – Check – Хэмжих, A – Adjust – Сайжруулах, Alignment – Уялдуулах

Өнгөрсөн хугацаанд эдгээр суурь тогтолцоог бүрдүүлэх журмуудаа батлуулан хэрэгжүүлж, ТУСС ХХК-аар 2025 онд хэмжүүлэхэд 93,8 хувиар ASA-1 түвшинг хангасан үзүүлэлттэй гарлаа.

Энэ загварыг хэрэгжүүлэх дараагийн үе шат бол Хэрэглэгчийн менежментийн; Үр чадварын менежментийн; Эрсдэлийн удирдлагын, Санхүүгийн менежментийн, Ханган нийлүүлэлтийн менежментийн гэсэн 5 дэд тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байдаг. Эдгээр дэд тогтолцооны хэв шинжийн бүрдүүлэлтийг ТУСС ХХК-аар 2025 онд хэмжүүлэхэд эрсдэлийн удирдлагын дэд тогтолцооны үнэлгээ 80,2 хувь, санхүүгийн менежментийн дэд тогтолцооны үнэлгээ 59,2 хувьтай гарлаа. Бусад дэд тогтолцооны хэмжүүр үзүүлэлт гаргаагүй байгаагаас хэмжигдээгүй болно.



3.1 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн мониторинг

2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав. 2025 онд нийт давтамжтайгаар болон нэг удаагийнхаар 19098 ажлыг гүйцэтгэж, гүйцэтгээгүй үлдсэн 79 ажилд оношилгоо хийн тухайн онд гүйцэтгэх шаардлагагүй гэж дүгнэсэн 36 ажлыг төлөвлөгөөнөөс хасч, 43 ажлын гүйцэтгэх хугацааг хойшлуулж дараа оны төлөвлөгөөнд тусгасан байна.

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	Нийт ажлын тоо	19177	19098	99.59%
1.1	ЖЖҮАТ-д туссан төлөвлөгөөт ажил	19140	19061	99.59%
1.2	ТГА ажлын тоо	37	37	100.00%
2	Зохицуулалт хийсэн ажлын тоо	0	79	0.41%
2.1	Зохицуулалт хийж хугацааг хойшлуулсан	0	43	0.23%
2.2	Зохицуулалт хийж ҮАТ-өөс хасагдсан ажлын тоо	0	36	0.19%

Системийн үйл ажиллагааны үр дүнг /СҮДҮ/-гийн мониторинг

Системийн үйл ажиллагааны үр дүнг оролцогч талуудын ашиг сонирхлыг тусгасан 6 үзүүлэлтээр хэмждэг бөгөөд Төлөвлөлтийн журмын дагуу жил бүр зорилтот түвшинг төлөөлөн удирдах зөвлөлөөр баталж, гүйцэтгэлийг тайлагнадаг бөгөөд 2025 онд СҮДҮ-ийн гүйцэтгэл 61.6%-ийн биелэлттэй байна.

2025 оны гүйцэтгэл				
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
1	Хэрэглэгчдэд бүтээсэн үнэ цэнэ	10,923,603.410	5,541,498.912	50.7%
2	Хөдөлмөрийн бүтээмж	176.278	100.111	56.8%
3	Ажилтанд бүтээсэн үнэ цэнэ	36.303	22.883	56.8%
4	Зардлын бүтээмж	1.425	1.011	71.0%
5	Хөрөнгийн бүтээмж-Хур/О	0.687	0.423	61.5%
6	Хөрөнгийн бүтээмж-ХОО	0.118	0.099	83.7%
Дундаж				61.6%



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Оношилгооны тайлан

Компанийн үйл ажиллагаанд тулгарч буй асуудал, төлөвлөгөө болон гүйцэтгэлийн хооронд зөрүү үүсч буй шалтгааныг тогтоох, шалтгаан, үр дагаварыг арилгах зорилгоор оношилгоо, мониторингийн зөвлөл байгуулан ажиллаж байна.

Компанийн оношилгоо, мониторингийн зөвлөлөөр 2025 онд нийт 201 оношилгоог хэлэлцүүлж, үүнээс 21 системийн доголдол, ажлыг хэрэгжүүлэхэд ажилтны мэдлэг, ур чадвар дутагдсан 40 тохиолдлыг илрүүлэн шалтгааныг арилгах ажлыг хэрэгжүүлж ажилласан байна.



Санхүүгийн дотоод хяналтын мониторинг

Компанийн санхүүгийн дотоод хяналтын чиг үүргийг Нэйшнл лайф даатгал ХХК-ийн толгой компани болох Гүнд Инвестмент ХХК хэрэгжүүлж байна. Үүнд:

Санхүүгийн үйл ажиллагааны дотоод аудитын хүрээнд мөнгөн гүйлгээ, авлага өглөгийн насжилтын тайлан болон барагдуулалтын мэдээлэлд хяналт тавих, Санхүүгийн тайлан болон татварын тайлангийн мэдээлэл үнэн зөв эсэхэд хяналт тавих, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дотоод дүрэм, журамд нийцсэн эсэхийг хянан баталгаажуулж алдаа зөрчлийг илрүүлж компанид мэдэгдэн залруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг даалгадаг. Мэдээллийн урсгалын журам, Санхүүгийн үйл ажиллагааны журмын хүрээнд 20 гаруй мэдээллийг тогтмол давтамжтай хүргүүлж байна.

Энэ хүрээнд Толгой компаниас компанийн санхүүгийн үйл ажиллагаанд ноцтой зөрчил гарсан дүгнэлт ирүүлээгүй. Хэвийн буюу аливаа алдаа, зөрчил илрээгүй болно.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

3.6 Шийдвэрүүд хууль, журамтай нийцэж байгаа байдал

Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлаас гаргасан шийдвэр нь хууль тогтоомж, дотоод дүрэм, журамд нийцсэн эсэхийг хянан баталгаажуулах, суурь тогтолцооны дүрэм болон журмын хэрэгжилтэд толгой компанийн дотоод хяналт хариуцсан хуульч нь мониторинг хийж гүйцэтгэлээ.

№	Журмын нэр	Журмын зорилгын хэрэгжилтийн түвшин /хувиар/
1	Оношилгоо, мониторингийн журам	85%
2	Төлөвлөлтийн журам	100%
3	Цалин хангамж урамшууллын журам	100%
4	Хөдөлмөрийн харилцааны журам	95%
5	Мэдээллийн урсгалын журам	100%
	Нэгдсэн дүн	95.96%

“Нэйшнл Лайф Даатгал” ХХК-ийн удирдлагаас 2025 онд нийт 151 шийдвэр гаргасан бөгөөд эдгээр нь бүгд холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, журамд нийцсэн байна.

№	Шийдвэр гаргах үүрэг бүхий этгээд	Зөрчилгүй шийдвэрийн тоо	Зөрчилтэй шийдвэрийн тоо	Нийт шийдвэрийн тоо
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал	3	0	3
2	Төлөөлөн удирдах зөвлөл	39	0	39
3	Гүйцэтгэх захирал	109	0	109
	Нийт	151	0	151

3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН





САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Даатгалын хураамжийн орлого

№	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025 он
1	Нийт хураамжийн орлого	2,565,360,705	3,000,457,025	3,455,991,205	5,108,475,495

Даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48%-аар өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Зээлдэгчийн амь насны даатгалын бүтээгдэхүүнээр арилжааны 8 банкттай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ипотекийн зээлдэгчийн амь насны даатгалд зээлдэгчид амьдралын даатгалд хамрагдах нөхцөлийг бүрдүүлсэн,
- Олон улсын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүний нөхцөлийг шинэчлэн, өрсөлдөх чадварыг сайжруулсан,
- Mylife.mn харилцагчийн порталд онлайн даатгал болон нөхөн төлбөрийн хүсэлт хүлээн авах шийдлүүдийг төгөлдөржүүлсэн нь даатгалын үйлчилгээний хүртээмж, борлуулалтын үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлсэн.

Хөрөнгө оруулалт

№	Үзүүлэлт	2024.IV	2025.IV	Өсөлт/Бууралт
1	Хөрөнгө оруулалтын багц	6,838.9	7,205.7	5.3%
2	Хөрөнгө оруулалтын орлого	1,203.5	1,197.6	-0.49%
3	Багцын дундаж өгөөж	21.0%	17.9%	-3.1%

Банкнүүдтай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд хугацаат хадгаламжийн хөрөнгө оруулалтын багцын эзлэх жин нэмэгдсэн нь багцын өгөөжийн түвшин буурахад нөлөөлсөн байна.

Цалин хөлс, нөөц сан

№	Үзүүлэлт	2024 он	2025 он	Залруулга
1	Цалин хөлс	1,002,330,837	1,116,492,000	-
2	Нөөц сан	4,054,471,121.70	4,397,596,054.09	4,398,288,716.79

Орлогын дэлгэрэнгүй тайлан

	Тод.	2025 Аудитлагдсан ₮'000	2024 (Дахин тайлагнасан) ₮'000
Даатгалын хураамжийн нийт орлого	7.1	4,430,785	3,455,991
Даатгалын хураамжийн буцаалт	7.1	(3,199)	(5,590)
Давхар даатгалын хураамжийн зардал		(47,540)	(37,858)
Даатгалын хураамжийн цэвэр орлого		4,380,046	3,412,543
Хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт		-	-
Орлогод тооцсон хураамж		4,380,046	3,412,543
Нийт нөхөн төлбөрийн зардал	7.3	(3,099,910)	(2,052,642)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр		-	-
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		(3,099,910)	(2,052,642)
Хувь оролцоогүй гэрээний нөөц сангийн өөрчлөлт	7.4	(233,607)	(979,739)
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангийн өөрчлөлт	7.5	8,127	(16,185)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт		-	-
Зардалд тооцсон нөхөн төлбөр		(3,325,390)	(3,048,566)
Даатгалын гэрээний зардал		(19,522)	(10,354)
Хөрөнгө оруулалтын орлого	7.6	1,041,243	1,173,697
Даатгалын үйл ажиллагааны ашиг		2,076,377	1,527,320
Бусад орлого	8	23,241	7,490
Борлуулалт, маркетингийн зардал	9.3	(212,139)	(253,803)
Ерөнхий ба удирдлагын зардал	9.2	(2,026,254)	(1,878,877)
Санхүүгийн орлого, (зардал)	10	4,897	19,988
Бусад ашиг алдагдал	9.1	(3,272)	(10,007)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз		7,376	(15,892)
Бусад ашиг (алдагдал)		(2,206,151)	(2,131,101)
Татварын өмнөх алдагдал		(129,774)	(603,781)
Орлогын татварын зардал	11	(89,367)	(100,911)
Тайлант жилийн алдагдал		(219,141)	(704,692)
Бусад дэлгэрэнгүй орлого			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	26	448,367	
Нийт бусад дэлгэрэнгүй орлого		448,367	
Нийт дэлгэрэнгүй орлого		229,226	(704,692)

Өмнөх тайлант үеийн дахин тайлагналын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 31-с харна уу.

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ

2025 оны санхүүгийн тайлангийн хараат бус аудитыг Мүүрь аудит ХХК-аар гүйцэтгүүлсэн бөгөөд тухайн аудитаас ““Санхүүгийн байдал болон уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ бүх материаллаг зүйлсийн хувьд СТОУС-д нийцүүлэн Сангийн сайдын баталсан дүрэм журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна” гэж дүгнэгдсэн болно.



Мүүрь Аудит ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо Олимпийн гудамж 7/3,
Центрум төв 7 давхар, 701 тоот
Утас : +976 7015 0003
Факс: +976 7015 0003
И-мэйл: info@moore-mongolia.mn
www.moore-mongolia.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид, Нэйшнл лайф даатгал ХХК-ийн (цаашид Компани гэх) 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д нийцүүлэн Сангийн яамнаас баталсан журам, зааврын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан)-д заасан олон нийтийн ашиг сонирхлын байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагууд болон Монгол улсын Аудитын тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагууд болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн дагуу тавигддаг бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжийн хүрээнд тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг бүхэлд нь авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

Аудитын гол асуудал**Бид аудитаар аудитын гол асуудлыг хэрхэн авч үзсэн****Даатгалын хураамжийн орлого /Тодруулга 7-г харна уу/**

2025 оны 12 сарын 31-нээрх Компанийн орлогын дэлгэрэнгүй тайланд 4,430,785 (2024: 3,455,991) мянган төгрөгийн даатгалын хураамжийн орлого тайлагнагдсан.

Компани нь урт хугацааны буюу амьдралын даатгал болон богино хугацааны даатгалын үйлчилгээ үзүүлдэг. Мөн даатгалын үйлчилгээг хуримтлалын бүтээгдэхүүнтэй хослуулан даатгуулагчдад хүргэдэг.

Компанийн урт хугацааны даатгалын хураамжийн орлого хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт нарийн төвөгтэй тул аудитын гол асуудал гэж үзсэн.

Даатгалын нөөц сан /Тодруулга 23-г харна уу/

2025 оны 12 сарын 31-нээрх Компанийн санхүүгийн байдлын тайланд 4,218,951 (2024: 3,985,333) мянган төгрөгийн хувь оролцоогүй гэрээний нөөц сан, 179,338 (2024: 69,138) мянган төгрөгийн хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан тайлагнасан.

Нөөц сангийн тооцоололд даатгалын актуарч болон удирдлагын томоохон төсөөлөл таамаглал, мэргэжлийн шүүн тунгаалт шаардагддаг. Мөн даатгалын гэрээний хамрах хугацаа урт байхын хэрээр тооцоололд

Бид дараах горимуудыг гүйцэтгэсэн:

Удирдлагын хэрэгжүүлсэн даатгалын хураамжийн орлого хүлээн зөвшөөрөлтийн НББ-ийн бодлогын зохистой байдлыг авч үзсэн ба Сангийн яамны заавар, аргачлалд нийцэж буй эсэхийг үнэлсэн;

Даатгалын гэрээ байгуулах хүртэлх үе шат, гэрээ байгуулсанаас гэрээ дуусах хүртэлх үе шатууд ба даатгалын хураамжийн орлогыг НББ-д бүртгэх үйл явцын талаар ойлголт олж авсан;

Даатгалын гэрээ байгуулах үе шат хүртэлх гол хяналтуудыг тестэлсэн;

НББ-д тусгасан хураамжийн орлогын холбогдох гэрээний мэдээллийг ERP програм дахь гэрээний мэдээлэлтэй тулган шалгаж, бүх гэрээнүүд санхүүгийн тайланд иж бүрэн тусгагдсан эсэхийг баталгаажуулсан;

Даатгалын гэрээнээс түүвэр сонгож, гэрээний хураамжийн орлогыг үнэн зөв, зохистой дүнгээр, зөв тайлант хугацаанд нь бүртгэсэн эсэх, орлогод тооцоогүй хураамж, даатгалын хураамжийн авлагын дүн үнэн зөв, иж бүрэн эсэхийг давтан тооцоолж шалгасан;

Даатгалын гэрээний нэмэлт хасалтыг зөв бүртгэсэн эсэхийг шалгах горимуудыг хэрэгжүүлсэн.

Бид дараах горимуудыг гүйцэтгэсэн:

Нөөц сангийн тооцооллын аргачлал нь СЗХ-ны баталсан Даатгалын багц дүрмийн 3 дугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын шаардлагуудад нийцсэн эсэх, нөөц сангийн хүрэлцээтэй байдлыг шалгасан;

Нөөц сангийн тооцоололд ашигласан дата өгөгдлүүдийн үнэн зөв, иж бүрэн, зохистой байдал, актуарчийн үнэлэмж, таамаглалын зохистой байдлыг үнэлсэн;

Нөөц сангийн тооцооллын аргачлал нь Компанийн даатгалын бүтээгдэхүүний дотоод журмуудтай нийцсэн эсэхийг шалгасан;



ирээдүйн тодорхой бус байдлын нөлөө ихтэй, тооцооллын аргачлал нарийн төвөгтэй зэрэгт үндэслэн аудитын гол асуудлаар тодорхойлсон.

Нөөц сангийн тооцооллын механик алдааг шалгаж, тооцооллыг давтан гүйцэтгэсэн.

Тасралтгүй байх зарчимтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

Нэйшнл лайф даатгал ХХК-ийн хувьд тайлант онд 219,141 (2024: 704,692, 2023: 216,361) мянган төгрөгийн алдагдалтай буюу сүүлийн дараалсан гурван жилийн хугацаанд алдагдалтай ажилласан байна. Мөн даатгагчийн төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлт “эргэлзээтэй” буюу гуравдугаар түвшинд хүрсэн байна. Иймд Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй зарчмаар үргэлжлүүлэн явуулах чадварт ихээхэн эргэлзээ төрүүлэхүйц материаллаг тодорхойгүй байдал оршин байна гэж дүгнэсэн. Энэ асуудалтай холбоотойгоор бид аудитын дүгнэлтийн хэлбэрт өөрчлөлт оруулаагүй. Бид санхүүгийн тайлангийн тодруулга 3.2-т энэ асуудлыг тодруулсан.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, мөн Компанийн үйл ажиллагааг зогсоох буюу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний аудитын зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах, мөн бидний дүгнэлтийг багтаасан аудитын тайлан гаргах юм. Үндэслэлтэй баталгаа гэдэг нь өндөр түвшний баталгаа боловч Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл оршин буй тохиолдолд үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба тэдгээр нь дангаараа эсвэл нийлээд тэдгээр санхүүгийн тайлангуудад үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрүүдэд нөлөөлөхөөр байвал тэдгээрийг материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг болгон бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж, мөн аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандана. Бид түүнчлэн:

- Санхүүгийн тайлангуудын залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг үнэлэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу үзүүлэх аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэнэ, мөн өөрсдийнхөө

дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай зохистой нотолгоо олж авна. Залилан нь үгсэн хуйвалдах, бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, гуйвуулах эсвэл дотоод хяналтыг үл хэрэгсэх зэргийг багтаасан байж болох учраас залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус, тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй байдлыг үнэлдэг
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадварт томоохон эргэлзээ үүсгэхүйц үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлнэ, мөн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар үндсэн гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг тусгасан эсэхийг үнэлдэг.
- Санхүүгийн тайлангуудад дүгнэлт илэрхийлэхийн тулд Компани доторх аж ахуйн нэгжүүд эсвэл бизнесийн үйл ажиллагаануудын санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай зохистой аудитын нотолгоо олж авдаг. Бид Компанийн аудитын ажлыг удирдан чиглүүлж, хянаж, гүйцэтгэхэд хариуцлага хүлээнэ. Бид өөрсдийн аудитын дүгнэлтдээ дангаар хариуцлага хүлээнэ.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа томоохон сул талыг багтаагаад илрүүлсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажилласан талаарх мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид хараат бус байдлын хүрээнд бүх харилцаа холбоо болон бодолцож үзвэл зохих бусад асуудлуудаар, хамааралтай бол, хараат бус байдалд учирсан сөрөг нөлөөнүүдийг арилгахын тулд авсан арга хэмжээнүүд буюу хэрэглэсэн хамгаалалтуудын талаар тэдгээр хүмүүстэй харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн үлэмж нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар тухайн асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд, аудиторын тайландаа тухайн асуудлаар харилцах нь уг харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа



харилцахгүй байх нь зүйтэй гэж бид үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр гол асуудлыг аудиторын тайландаа тусгадаг.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт 2025 оны 12 сарын 31-нээр тасалбар болсон Компанийн жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайлан болон манай аудитын тайлан үүнд хамаарахгүй.

Санхүүгийн тайланд илэрхийлсэн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй буюу бид үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй болно.

Бидний гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг уншиж танилцан, бусад мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлох үүрэгтэй.

Хэрэв бусад мэдээлэл нь материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй. Нэйшнл лайф даатгал ХХК-ийн 2025 оны жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлангаас хойш бидэнд танилцуулагдахаар хүлээгдэж байна. Хэрэв жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл холбогдох арга хэмжээг дурдан бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх болно.

Хууль эрх зүйн болон зохицуулалтын бусад шаардлагуудын тайлан

Даатгалын компанийн төлбөрийн чадвар

СЗХ-ны 2025 оны 02 сарын 25-ны өдрийн 66 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам"-ын 2.19-д заасны дагуу Компанийн төлбөрийн чадвар 2025 оны 12 сарын 31-ний байдлаар Гуравдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар эргэлзээтэй (2024: Хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай) түвшинд байна.



Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, Центрум төв, 7 давхар 701 тоот. **Утас:** 976-7015 0003, **И-мэйл:** info@moore-mongolia.mn